



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/149

Эг

**Хяналт тавих ажлын хэсэг
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нийт нутаг дэвсгэрт байгаль орчин, байгалийн нөөц ашиглалтад батлагдсан удирдамжийн дагуу эргүүл хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнх-Очир

Байгаль орчны хяналтын улсын
байцаагч

Нарийн бичиг: Ч.Ундармаа

Сум дундын Ойн ангийн дарга

Гишүүд: Р.Болор-Эрдэнэ

Хэсгийн Төлөөлөгч ахлах дэслэгч

Д.Бат-Өлзий

Хан Хэнтий улсын Тусгай

хамгаалалттай газрын хэсгийн ахлагч

Б.Минжинсор

Нягтлан бодогч

2. Самрын бэлтгэх тээвэрлэлт болон бусад байгаль орчны холбогдох орлогын биелэлт, эрхийн бичгийн олголтод хяналт тавин, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнх-Очир)-т үүрэг болгосугай.

3. Зохион байгуулсан ажлын тайланг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор нэгтгэн танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

4. Эрүүл хяналтын зардлыг Байгаль хамгаалах нөхөн сэргээх сангийн зардлын хөрөнгөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Минжинсор)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАЛТАНГЭРЭЛ

202401393